



БОЛОВСРОЛЫН
ЯАМ



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ЯАМ



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



From
the People of Japan



Save the
Children

“ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ, ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ (2025-2026)

МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС №2 2025 оны 11 дүгээр сар



Төслийн менежер Като Шоко Баянзүрх дүүргийн 320 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ц.Цогзолмаад
Хүүхэд хөгжлийн танхимын техник хэрэгсэл гардуулах үеэр, 2025 оны 10-р сарын 21.

ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА



Судалгааны хүрээнд асуумж, түлхүүр мэдээлэгчийн ярилцлага зэрэг тоон болон чанарын аргаар нийт **297 оролцогчоос** мэдээлэл цуглуулав.

“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн суурь судалгааг Когнос Интернэйшнл байгууллага 2025 оны 5-8 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэв. Суурь судалгаанд төслийн хоёр дахь жилийн зорилтот таван байршлын цэцэрлэг, Өрхийн эрүүл мэндийн төв (ӨЭМТ) болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс (салбар комисс)-ын төлөөлөл, зорилтот цэцэрлэгт суралцдаг хүүхдүүдийн эцэг эхчүүдийг хамруулснаас гадна бодлогын түвшний нөхцөл байдлыг тодруулах зорилгоор төв комисс болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Боловсролын яамны төлөөллүүдийг хамрууллаа. Судалгааны хүрээнд асуумж, түлхүүр мэдээлэгчийн ярилцлага зэрэг тоон болон чанарын аргаар нийт 297 оролцогчоос мэдээлэл цуглуулав.

Суурь судалгааны гол зорилго нь бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, оролцооны чиглэлээр хэрэгжиж байгаа бодлого, үйл ажиллагаа, өрхийн эрүүл мэндийн төв, цэцэрлэгүүдийн хүүхдэд үзүүлж буй хөгжлийн цогц үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал, оролцогч талуудын оролцоог цогцоор үнэлж, суурь мэдээлэл цуглуулах, судалгааны үр дүнд үндэслэн санал зөвлөмж боловсруулах явдал байв.

Судалгааны үр дүнгээс үзэхэд:

- ӨЭМТ-ийн эмч нарын бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх чадавх дунд түвшинд байгаа бөгөөд эмч нарын сургалт, эмнэлгийн тоног төхөөрөмж, дэд бүтэц, хамтын ажиллагаа, эцэг эхийн оролцоо зэрэг олон хүчин зүйлс хангалтгүй байгаагаас хүүхдийн хөгжлийн асуудлыг эрт илрүүлэх, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учирч байна.
- Салбар комисс үйл ажиллагаагаа дунджаар 73% гэж үнэлсэн ч бодлого, зохицуулалтын орчин дутмаг, хүний нөөц тогтворгүй, дата мэдээллийн цахим платформ байхгүй зэргээс улбаалан үйл ажиллагаа тогтвортой, үр дүнтэй байж чадахгүй байна.
- Цэцэрлэгүүд хөгжлийн бэрхшээлтэй, хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдийг ялгалгүйгээр хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд тохирсон заавар чиглүүлэг, хөгжлийн дэмжлэг үзүүлэх орчин нөхцөл бүрдсэн байдлаа дунджаар 64.6% гэж үнэлсэн. Эцэг эхчүүдийн хувьд хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх, тусламж үйлчилгээний талаарх ойлголт нэмэгдэж байгаа ч хүүхдийн нас дээшлэх тусам эрүүл мэндийн цогц үзлэгт хамруулах нь багасах,

хүүхдэд нь ямар нэгэн хөгжлийн хоцрогдол, бэрхшээл илэрвэл хаанаас тусламж авахаа мэдэхгүй байх зэрэг асуудлууд байна.

➤ Төслийн хүрээнд бага насны тусгай хэрэгцээтэй хүүхдийн эрт илрүүлэг, тэдэнд үзүүлэх хөгжлийн дэмжлэгийг сайжруулах зорилгоор бодлого, эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэх, засан сайжруулах зорилготой бодлогын уулзалтуудыг гурван яамны төлөөллийг оролцуулан тогтмол

зохион байгуулж байна. Энэ нь одоогийн бодлогын хэрэгжилт, эрх зүйн орчныг сайжруулах, нийгмийн салбарын яамдын оролцоо, хүчин чармайлтыг нэгтгэхэд ач холбогдолтой.

Дээрх үр дүнд үндэслэн цаашид анхаарах шаардлагатай үйл ажиллагааг ӨЭМТ, цэцэрлэг, салбар комиссын түвшинд, эцэг эх, олон нийтийн түвшинд, бодлого хэрэгжилтийн түвшинд тус бүрд нь зөвлөсөн байна.

“НЯЛХ, БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХОЦРОГДОЛ, БЭРХШЭЭЛИЙГ ЭРТ ИЛРҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ

2025 оны 10 дугаар сар

“Нялх, бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх нь” сэдэвт сургалтыг 09-р сарын 29 – 30, 10 сарын 1-ний өдрүүдэд төслийн зорилтот Баянхонгор, Сэлэнгэ аймаг мөн нийслэлийн Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдийн эхний жилийн болон хоёр дахь жилийн зорилтот Өрхийн эрүүл мэндийн төв, цэцэрлэгийн эмч, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч нар, Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдийг хамруулан Цус Судлалын Үндэсний төвийн сургалтын танхимд тус тус зохион байгууллаа.

Сургалтад нийт 54 эмч, эмнэлэг, цэцэрлэгийн мэргэжилтнүүд хамрагдаж бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, оношлох, хүндрэлээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг чадвараа дээшлүүлээ. Сургалтын эхний 2 өдөр 2025 онд шинээр төсөл хэрэгжиж буй өрхийн эмнэлэг, цэцэрлэгийн эмч нар хамрагдсан бол,

сүүлийн өдөр 2024 онд төсөл хэрэгжсэн өрхийн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд өнгөрсөн жилийн мэдлэг чадвараа бататган, төслийн үйл ажиллагааны хүрээнд хэвлэгдэн гарсан гарын авлагын шинэчлэлтэй танилцаж эмнэл зүйн үйл ажиллагаандаа тусган ажиллахаар боллоо.

Сургалтын явцад эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг илрүүлэн эмчилгээ оношилгоонд хамруулахад анхан шатны эрүүл мэндийн байгууллагад тохиолддог бэрхшээлийг хэрхэн шийдэх талаар туршлагаа солилцох боломж бүрдсэн бөгөөд өрхийн эрүүл мэндийн төв болон цэцэрлэгийн, хот хөдөөгийн эмч нар хамтран сургалтад хамрагдсанаар хүүхдийн хөгжлийн хоцрогдлоос сэргийлэх үйл ажиллагааг чанартай зохион байгуулах, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо сайжрахад дэмжлэг болох юм.



Сургалтад оролцогчид Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлсэн эмнэлийн тоног төхөөрөмжийг ашиглан нүдний хөгжлийн хоцрогдол илрүүлэх дадлага хийж байна. 2025 оны 9-р сарын 29, Цус судлалын үндэсний төвийн сургалтын танхим



Төслийн зөвлөх эмч Б.Баясгалантай "Монгол хүүхдийн хөгжлийг үнэлэх - Морбас хүснэгт"-ийг ашиглах аргачлал танилцуулж байна. 2025 оны 9-р сарын 30, Цус судлалын үндэсний төвийн сургалтын танхим



2025 онд шинээр төсөл хэрэгжиж буй Өрхийн эрүүл мэндийн төв, цэцэрлэгийн эмч нар сургалтыг удирдсан багш нарын хамт, 2025 оны 9-р сарын 30, Цус судлалын үндэсний төвийн сургалтын танхим



Төслийн зөвлөх эмч Л.Тунгалаг шинэчлэгдсэн сургалтын гарын авлагыг танилцуулж байна. 2025 оны 10-р сарын 1, Цус судлалын үндэсний төвийн сургалтын танхим

САЛБАР КОМИССЫН ГИШҮҮДИЙН ЧАДАВХ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ

2025 оны 9 дүгээр сар

“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн хүрээнд Улаанбаатар хотын зорилтот Баянзүрх, Сонгино Хайрхан, Чингэлтэй дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийн чадавх бэхжүүлэх сургалт 2025 оны 9-р сарын 17, 18-ны өдөр Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн хурлын танхимд боллоо.

Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэгийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах үйл явцад салбар комиссын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, үр дүнтэй хөгжлийн дэмжлэг үзүүлэхэд салбар дундын уялдааг хангаж, холбон зуучлах, оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий уг сургалтыг төслийн зөвлөх багийн ахлагч, доктор Г.Соёлгэрэл, зөвлөх багийн гишүүн, хүүхдийн эмч Р.Галбадрах нар удирдан явууллаа.

Мөн сургалтын үеэр ГБХНХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комиссын мэргэжилтэн Б.Янжмаа, М.Мэндээ нар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээрх бодлого, хэрэгжилт, төсөв санхүүжилт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийн талаарх танилцуулга, мэдээлэл хийв.

Түүнчлэн уг сургалтыг Баянхонгор аймагт 10-р сарын 8, 9-ний өдрүүдэд төслийн баг зөвлөх багийн гишүүн, хүүхдийн эмч Р.Галбадрахтай хамтран зохион

байгууллаа. Сургалтын 2 дахь өдөр Биеийн үйлдэл, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн олон улсын ангилал (ICF)-д тулгуурлан нийт хөгжлийн бэрхшээлтэй бага насны 3 хүүхдэд эцэг эхийн хамт хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах (2), кейс хэлэлцүүлэг (1) хийх дадлага хичээлийг явуулсан бөгөөд өрхийн ЭМТ-ийн эмч, цэцэрлэгийн эрхлэгч, багш, эмч, багийн засаг дарга, нийгмийн ажилтан нар маш идэвхтэй оролцсоноороо илүү шинэлэг, үр дүнтэй боллоо. Энэхүү сургалтыг 10-р сардаа багтаан Сэлэнгэ аймагт явуулах юм.



Биеийн үйлдэл, Хөгжлийн бэрхшээл, Эрүүл мэндийн олон улсын ангилал-ыг (ICF) ашиглан хүүхдийн хөгжлийг үнэлж, хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах бүлгийн ажил, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн хурлын танхим, 2025 оны 09-р сарын 18



ӨЭМТ-ийн эмч дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах практик ажлын үеэр хүүхдийн бодит байдлын үнэлгээг танилцуулж байна. Баянхонгор аймгийн МВ зочид буудлын хурлын танхим, 2025 оны 10-р сарын 09

“СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ НАРЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН МОДУЛЬ”-ИЙН СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ

2025 оны 8 дугаар сар

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль"-ийн сургагч багш бэлтгэх сургалт 2025 оны 08-р сарын 26-27-ны өдрүүдэд Эрүүл мэндийн хөгжлийг дэмжих төвийн сургалтын танхимд амжилттай зохион байгуулагдлаа.

Тус сургалтад Баянхонгор, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нийт 10 цэцэрлэгийн 23 арга зүйч, багш, бага боловсролын мэргэжилтнүүд хамрагдлаа. Сургалтын модулийг МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн зөвлөх багш Ж.Батдэлгэр ахлагчтай баг 2024-2025 оны хичээлийн жилд боловсруулан туршин хэрэгжүүлэхэд хамтран ажилласан юм.

Энэ хичээлийн жилд тус модулийг:

- Бага насны хүүхдийн ялгаатай хэрэгцээг дэмжих арга зам, стратеги
- Эерэг зан үйлийг дэмжих арга зүй
- Цэцэрлэгээс сургуульд шилжин суралцах үеийн үйл ажиллагаа зэрэг практик, арга зүйн мэдлэг, мэдээллийг нэмж, дахин сайжруулж боловсруулсан болно.

Эдгээр сургагч багш нар нь цэцэрлэг, аймаг, дүүргийн хэмжээнд тусгай хэрэгцээт хүүхдүүдэд бие бялдар, сэтгэл зүй, суралцах орчны дэмжлэгийг үзүүлэх, тусгай хэрэгцээтэй хүүхдийг цэцэрлэгээс ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцах бэлтгэлийг хангах, ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг давтан зохион байгуулж, түгээн дэлгэрүүлэх юм.



Сургалтад оролцогчид сургалтын орчин бүрдүүлэх бүлгийн ажил хийж байна. Эрүүл мэндийн хөгжлийг дэмжих төвийн сургалтын танхим, 2025 оны 08-р сарын 27



Оролцогчид хүүхдийн ялгаатай хэрэгцээг дэмжих стратеги дадлага ажил хийж байна. Эрүүл мэндийн хөгжлийг дэмжих төвийн сургалтын танхим, 2025 оны 08-р сарын 27

“БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХЭД ЭЦЭГ ЭХИЙН МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ САЙЖРУУЛАХ, ҮҮРЭГ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗҮЙ” СУРГАЛТЫН МОДУЛИЙН СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ

2025 оны 8 дугаар сар

2025 оны 8-р сарын 28, 29-ний өдрүүдэд “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн мэдлэг ойлголтыг сайжруулах, үүрэг оролцоог нэмэгдүүлэх арга зүй” сургалтын модулийн сургагч багш бэлтгэх сургалт Эрүүл мэндийн хөгжлийн төвийн сургалтын танхимд амжилттай зохион байгуулагдлаа. Сургалтад Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг, Баянхонгор, Сэлэнгэ аймгийн нийт 10 цэцэрлэгийн 30 багш, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны 5 салбарын зохицуулагчид, Баянхонгор аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын хөгжлийн төвийн 2 багш зэрэг нийт 37 оролцогч идэвхтэй оролцлоо.

Сургалтын үеэр оролцогчид дараах сэдвүүдийн хүрээнд бүлгийн ажилд оролцох, видео танилцуулгатай танилцах, дадлага ажил, хэлэлцүүлэг хийх зэрэг бүтээлч хэлбэрээр суралцлаа. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх арга зам
- 0–5 насны хүүхдийн хөгжлийн онцлог, түүнийг танин мэдэх ач холбогдол
- Хөгжлийн ялгаатай онцлогтой хүүхдүүдийн талаарх ойлголт
- Эцэг эх, багшийн хамтын ажиллагаа, хөгжлийн хамтарсан

төлөвлөгөө боловсруулах

- Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн хөгжлийг дэмжихэд багш–эцэг эхийн харилцах дэвтэр ашиглах

Сургалтад хамрагдсан оролцогчид өөрсдийн байгууллагын багш, эцэг эхчүүдэд энэхүү сургалтыг зохион байгуулах чадавхтай сургагч багш боллоо.



Сургалтад оролцогчид, Эрүүл мэндийн хөгжлийн төв II байрны сургалтын танхим, 2025 оны 8-р сарын 29.



Зөвлөх Б. Норовдоо танилцуулга хийж байна. Эрүүл мэндийн хөгжлийн төв II байрны сургалтын танхим, 2025 оны 8-р сарын 28.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН УУЛЗАЛТ

2025 оны 9 дүгээр сар

2025 оны 9-р сарын 12-ны өдөр Сэлэнгэ аймагт хэрэгжиж буй “Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн удирдах зөвлөлийн 2 дахь уулзалт Сэлэнгэ аймгийн Милофа төвийн уулзалтын танхимд боллоо. Уулзалтад Аймгийн Засаг даргын 2025 оны А/222 дугаар захирамжаар батлагдсан



Аймгийн Засаг даргын
2025 оны А/222
дугаар захирамжаар
батлагдсан удирдах
зөвлөлийн гишүүд,
төслийн зорилтот
байгууллагуудын
төлөөллөөс бүрдсэн
7 гишүүн оролцлоо.



Уулзалтад оролцогчид, Милофа төвийн уулзалтын танхим, 2025 оны 9-р сарын 12.



Оролцогчид хэлэлцүүлэг хийж байна. Милофа төвийн уулзалтын танхим, 2025 оны 9-р сарын 12.

удирдах зөвлөлийн гишүүд, төслийн зорилтот байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн 7 гишүүн оролцлоо. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, Хүүхэд, Гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны дарга нар болон холбогдох мэргэжилтнүүд байдаг.

Хурлын үеэр Ж.Очгэрэл 4-9 дүгээр сард хэрэгжүүлсэн төслийн үйл ажиллагааны үр дүнг, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг танилцууллаа. Мөн хуралд оролцогчид танилцуулсан асуудлын талаар санал бодлоо нээлттэй солилцож, цаашдын хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамтран төлөвлөх, харилцан уялдаа холбоотой ажиллах талаар зөвшилцсөн чухал уулзалт боллоо.

ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ “ МОНГОЛЫН БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН СҮЛЖЭЭ”

2025 оны 9 дүгээр сар

Эгнээндээ 30 гаруй гишүүн байгууллагыг нэгтгэсэн “Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ” нь 2022 онд байгуулагдсан бөгөөд хойш салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих, мэдлэг, туршлагаа харилцан солилцох, шинэ санаачилга, түншлэлийг бий болгох зорилготой үндэсний байгууллага юм. Энэхүү сүлжээ байгууллагын улирал тутмын ээлжит уулзалтыг Японы Хүүхдийг Ивээх сан 2025 оны 9-р сарын 24-ны өдөр зохион байгууллаа. Тус уулзалтаар “Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн Сонгино-Хайрхан дүүргийн зорилтот 117 дугаар цэцэрлэг, “Ээлтэй”

Өрхийн эрүүл мэндийн төв дээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай танилцлаа. Уулзалтын үеэр төслийн зохицуулагч Ч.Пүрэв-Очир, 117-р цэцэрлэгийн эрхлэгч П.Амаржаргал нар өөрийн байгууллага болон төслийн үр дүнтэй танилцуулж, оролцогчдын тавьсан асуултад хариулж ярилцлаа. Ярилцлагын дараа тус төслөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сурч хөгжихөд зориулан байгуулсан “Хүүхдийн хөгжлийн дэмжих танхим”-тай танилцлаа. Мөн ердийн хүүхдүүдтэй хамт суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн анги танхимаар зочилж, багш нарын хүүхэдтэй ганцаарчлан ажиллаж буй арга зүйг ажиглаж тэдэнтэй ярилцлаа.



Уулзалтад оролцогчид 320 цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаатай танилцаж байна. 2025 оны 9-р сарын 24, 320 дугаар цэцэрлэг

Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлдэг “Ээлтэй” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга С.Нямшүр болон бусад эмч ажилтнууд байгууллагынхаа талаар болон төслийн үр дүнгийн талаар танилцуулга хийлээ. Төслийн хүрээнд зохион байгуулсан бага насны хүүхдийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг үзүүлэх арга зүйн сургалтуудад тус төвийн эмч, ажилтнуудын суралцаж эзэмшсэн арга зүй, хүүхдийн өсөлт хөгжлийн үнэлгээ, эрүүл мэндийн үзлэг хийх өрөөг тохижуулсан, 9, 18, 36 сартай хүүхдийн үзлэг, тэдэнд үзүүлж буй үйлчилгээг чанаржуулж байгаа зэрэг

сайн туршлагаасаа хуваалцлаа.

Энэхүү уулзалтад сүлжээний гишүүн байгууллагууд болох НҮБ-ын Хүүхдийн сан, Лоринет сан, Азийн сан, Дэлхийн зөн ОУБ, Гоод Нэйборс, OneSky, БСҮХ, Энэрлийн түүчээ ТББ зэрэг байгууллагуудын 20 гаруй төлөөлөл оролцлоо. Оролцогчид энэхүү уулзалтыг зохион байгуулж, төслийн үр дүн, туршлагаасаа хуваалцсан Японы Хүүхдийн ивээх сангийн “Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн багт талархал илэрхийллээ.



Уулзалтад оролцогчид санал бодлоо солилцож байна. 2025 оны 9-р сарын 24, 320 дугаар цэцэрлэг



“Ээлтэй” ӨЭМТ-ийн дарга С.Нямшүр төслийн үр дүнг танилцуулж байна. 2025 оны 9-р сарын 24, ӨЭМТ



ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Улаанбаатар хотын гурван дүүрэг, Сэлэнгэ болон Баянхонгор аймгийн зорилтот төрийн үйлчилгээний байгууллагуудад бага насны хүүхдийн хөгжлийг тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр дэмжих тогтолцоог бий болгоно.



ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД

1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тогтолцоог сайжруулах, чадавхыг бэхжүүлэх;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын чадавхыг бэхжүүлэх;
3. Цэцэрлэгийн чадавх, тогтолцоог бэхжүүлж, цэцэрлэгт хамрагдаж буй тусгай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцах үйл явцыг дэмжих;
4. Эцэг эхчүүд болон олон нийтэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах;
5. Засгийн газарт хандсан бодлогын нөлөөлөл, дэмжлэг үзүүлэх;



ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

Япон улсын Гадаад Хэргийн Яам



ТӨСЛИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:

2025 оны 3-р сар- 2026 оны 3-р сар



ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БҮЙ БАЙГУУЛЛАГУУД

Эхний жил

Аймаг/ дүүрэг	ӨЭМТ	Цэцэрлэг
Баянзүрх дүүрэг	“Ачлахуй” ӨЭМТ	32 дугаар цэцэрлэг
Сонгино-Хайрхан дүүрэг	“Ээлтэй” ӨЭМТ	117 дугаар цэцэрлэг
Чингэлтэй дүүрэг	“Энэрэнгүй үйлст ” ӨЭМТ	18 дугаар цэцэрлэг
Баянхонгор аймаг	“Энхбүрд” ӨЭМТ	16-дугаар цэцэрлэг
Сэлэнгэ аймаг	“Эмнэх баг” ӨЭМТ	6-дугаар цэцэрлэг

Хоёрдахь жил

Аймаг/ дүүрэг	ӨЭМТ	Цэцэрлэг
Баянзүрх дүүрэг	“Нэмүүлэн” ӨЭМТ	320 дугаар цэцэрлэг
Сонгино-Хайрхан дүүрэг	“Анан” ӨЭМТ	81 дүгээр цэцэрлэг
Чингэлтэй дүүрэг	“Мэнд аривжих” ӨЭМТ	83 дугаар цэцэрлэг
Баянхонгор аймаг	“Оточ манал” ӨЭМТ	1 дүгээр цэцэрлэг
Сэлэнгэ аймаг	“Номт хан” ӨЭМТ	3 дугаар цэцэрлэг

 ҮР ШИМИЙГ ХҮРТЭГСЭД:

Шууд: 3,600 **Шууд бус:** 125,000



 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
 +976-11-329365, +976-11-329371
 +976-11-329361

 secretary@savethechildren.mn
 mongolia.secretary@savethechildren.org
 Save the Children in Mongolia
 Save the Children MN